



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 4/59

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 388 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол улсын 2019 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан Эрүүл мэндийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Жагсаалт батлах тухай” А/05 дугаар тушаалын XVII.2.7.16 Нэгдсэн эмнэлгийн цонхны их засвар /Сэлэнгэ, Мандал сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, төсвийг зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх/-ийг Сэлэнгэ аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д шилжүүлсүгэй.

2. Эрүүл мэндийн сайд, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан Хамтран ажиллах гэрээний 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт “Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэлээр санхүүжүүлэх”, 3 дугаар зүйлийн 3.2.17 дахь хэсэгт “Төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулж санхүүжүүлэх”, 3 дугаар зүйлийн 3.1.18 дахь хэсэгт “Эрүүл мэндийн сайдаас аймгийн Засаг дарга нарт эрх шилжүүлсэн ажлын явцын мэдээллийг сар бүр Эрүүл мэндийн яаманд дараа сарын 05-ны өдрийн дотор хүргүүлэн” тайлагнаж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д зөвлөсүгэй.

3. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг Нийслэлийн болон орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулан хэрэгжүүлэхийг “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын дарга /Ц.Амарсанаа/-д даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Бямбадорж/-д үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080324